МИНИЙ БИЗНЕС

ОНЛАЙН ДАСГАЛЖУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР

“МИНИЙ БИЗНЕС” ХӨТӨЛБӨРТ

ТАВТАЙ МОРИЛ

Таныг өөртөө хөрөнгө оруулж, Монголын ирээдүйд хөрөнгө оруулж, өдөр бүр тэмцэж хөдөлмөрлөх гайхалтай энэ замыг сонгосонд бид баяртай байна.

Тантай уулзах энэ өдрийг иртэл би хичнээн олон жил хөдөлмөрлөж, хичнээн их мэдлэг туршлага хуримтлуулж, түүнийгээ Монголчууддаа хүргэх өдрүүдийг тэсэн ядан хүлээсэн гэж бодож байна?

Гайхалтай! Үнэхээр гайхалтай сайхан амьдралыг хүн өөрийн хоёр гараар, энэ биеэрээ мэдэрч туулж болохыг би танд энэ хөтөлбөрөөр дамжуулж хүргэхийг зорьж байна.

Манай бусад оролцогчид ч бас таныг орж ирсэнд, танаар дамжуулж бид ямар их боломжийг хамтдаа суралцах бол гэж бодохоос тэсэн ядан хүлээж байгаа гэдэгт итгэлтэй байна.

Бид өнөөдрөөс эхлээд ирэх 2 жил хамтдаа бизнесийн томоохон сэтгэлгээ тэлж, томоохон амжилтын ард гарах их замд алхах гэж байна. Энэ алхаа маань амархан биш гэдгийг би танд шударга сануулах нь зүйтэй байх. Сэтгэлзүйн бэлтгэлтэйгээ бизнесийн дасгалжуулалт авахаар орж ирсэн танд би шаардлагатай зөв чиглэл рүү хурц оюун ухаанаа дайчлахад эртхэн чиглүүлээд өгсөн нь дээр шүү тэ, тийм ээ? Эзэн хичээвэл заяа хичээнэ гэж бид ярьдаг. Эндээс л эхэлье.

Бизнесийн амжилтыг юу тодорхойлдог вэ? Бизнесийг манлайлж яваа хүний алсын хараа сэтгэхүй л тодорхойлдог. Тиймээс л бид “Миний Бизнес” гэсэн хандлагатайгаар өөрийнхөө өмнөх бизнесийг эзэн шиг эзэн нь байгаад амжилтанд хүргэх манлайлагчийн чадварыг танд олгох байгаа.

Амжилттай бизнесийн хөрөнгө оруулалтын 3 үе шат байдаг. Хамгийн эхний хамгийн амархан хувилбар бол мөнгөөр хөрөнгө оруулах. Энэ хөтөлбөрт оролцохдоо та өөртөө зориулаад 5 сая төгрөг төлсөн. Энэ бол эхний шалгуур.

Харин 2 дахь шалгуур нь та оруулсан хөрөнгө оруулалтаа өөртөө шингээж суралцах цаг гаргах асуудал. Та суралцахгүйгээр, өөртөө цаг гаргаж, оюун ухаандаа шингээхгүйгээр бол таны төлсөн 5 сая төгрөг, танд бэлэглэсэн бонус[1] жил урсаад л өнгөрнө. Та хөтөлбөрийнхөө хичээлүүдийг бие даан суралцаж, онлайн уулзалтандаа цаг гарган идэвхтэй оролцох нь маш чухал. Та цаг гаргаж сурахгүй бол таны бизнесийг амжилтанд хүргэх хэн ч байхгүй.

Хөрөнгө оруулалтыг тань амжилттай болгох 3 дахь хамгийн том, хамгийн чухал шалгуур бол та үйлдлүүд хийх. Үүгээрээ л манай хөтөлбөрүүд ид шидтэй. Би танд хоосон онол заахыг хүсэхгүй, таны бодит бизнесийн амжилтанд нөлөөлөх зөв чиглүүлэх зөвлөгөө алхмыг таны үйлдэлгүйгээр бид бий болгож чадахгүй. Та үйлдэл хийх ёстой. Үйлдэл хийсэн хүн л үр дүнг гаргана. Үр дүн гаргасан хүн л бизнесийн амжилтыг олно. Ажил хийвэл амт тосдоно гэдэг шиг.

Өнөөдөр би таныг энэ гайхалтай чухал зорилгодоо, энэ гайхалтай мөрөөдлийн аялалд маань надтай зэрэгцэн аялахаар сонирхож байгаад баяртай байна. Би таныг хувийн амьдралынхаа өмнө тулгарсан бэрхшээлүүдийг шийдээд зогсохгүй, бусдын амьдралын Бэрхшээлийг шийдэх чадвартай гэдэгт бүрэн итгэж байна.

“Миний Бизнес” хөтөлбөрийн зорилго бол таны өнгөрсөн олон жилүүдийн туршид хурцлагдаж, ухааруулж, чиглүүлж явсан тэр их мэдлэг, туршлага, ур чадварыг хэзээнээс хойш хийхийг хүсээд байсан дуртай ажил, бизнесээрээ дамжуулан ид шидийг гаргаж ирэхэд чинь туслах юм.

Энэ хөтөлбөр таныг энийг л хийх гэж төрсөн юм гэж бахархмаар тэр гайхалтай сэтгэлийн урам, тэмүүлэл болгоныг илэрхийлж чадах тэр ажлыг л зоригтойгоор барьж авахад тань туслах гарын авлага, арга хэрэгслийг тань бэлэглэх болно.

Таныг цоо шинээр бизнесийн аялалд гарч байгаа ч бай, аль хэдийнэ хийж эхлүүлсэн бизнестээ шинэ амьсгал чиглэл оруулж байсан ч ялгаагүй, би таны энэ мөрөөдлийг бодитоор олж харахад туслах болно.

Миний энэ хөтөлбөртөө танилцуулж болгож буй энэ арга стратегиудыг ашиглаж буй Дэлхийн даяар олон мянган бизнесменүүд, саятнууд менторууд ашиглаж байгаа. Тэдний хийсэн туршлагаас, заасан аргуудыг би Монголын зах зээл дээр байнга ашигладаг.

Энэ бүх аргыг би ганцаараа биш, Монголын нийгэм, шинэ үе тун удахгүй өдөр тутмын иддэг талх мэтээр өргөн ашиглаж эхлэх болно. Анхдагчид тухайн салбартаа тэргүүлж од мэт гялалзаж явахын бэлгийг давхар дагуулдаг. Тэгвэл би таныг од мэт үнэ цэнэтэйгээр гялалзах диамондоо олж авах аянд урьж байна.

Гайхалтай!

Одоо би танд хөтөлбөртөө хэрхэн оролцох талаар товчхон танилцуулъя.

MONICA BATSUKH
ТОВЧ ЗАМНАЛ

- 1976 онд УБ хотод төрсөн.
- 1984-1994 онд УБ хотын 84-р сургуульд суралцаж төгссөн
- 1994-1995 онд Төмөр Замын Их Сургуульд суралцсан.
- 1995-1996 онд МУИС-ын Хятад хэлэнд суралцсан.
- 1996- 2000 онд Бээжингийн Зам Харилцаа Холбооны Их Сургуульд “Олон улсын тээвэр зохион байгуулалтийн инженер” мэргэжлээр суралцаж төгссөн.
- 2000-2003 онд байгуулагуудад гэрээт мэргэжилтнээр ажилласан.
- 2003 - онд Англи улс руу явсан. Өнөөг хүртэл Лондон хотноо ажиллаж амьдарч байна.
- 2008 онд “Баян аав Ядуу аав” номын зохиолч Роберт Т Киёосакигийн дасгалжуулалтын хөтөлбөрт ажилласан.
- 2007-2009 онд Master NLP буюу Сэтгэхүйн Хэлзүйн Програмчлалын Мастер эрх авсан.
- 2009-2011 онд Амьдралын Дасгалжуулагчийн Академид, Амьдралын Дасгалжуулагч мэргэжлийн эээмшиж, чадваржсан. Мэргэшсэн Дасгалжуулагч эрхээ авсан.
- 2011 онд “Бэрхшээл ба Боломж” номоо монгол хэл дээр хэвлүүлж гаргасан.
- 2012 оноос Entrepreneur Business Academy бизнес ментор хөтөлбөрт ажилласан. Энтерпрайз ментор эрхээ авч бизнесийн хөтөлбөрүүд дээр ажилласан.
- 2013 онд “Бэрхшээл ба Боломж” podcast цувралууд 3хан сард 20000 удаа татагдсан.
- 2013 онд “Бэрхшээл ба Боломж” аудио номоо уншиж гаргасан.
- 2013 онд Мөнгө ба Миний Үнэ Цэнэ номоо хэвлэж гаргасан.
- 2014 онд Мөнгө ба Миний Үнэ Цэнэ аудио номоо уншиж гаргасан.
- 2014 оноос Онлайн уулзалтын видеонууд 100000 дээш тоогоор олны хүртээл болсон.
- 2015 онд “Entrepreneur Mastermind” хөтөлбөрт Scholarship эрхээр шагнуулсан. Serial Entrepreneur Ричард Брансон-ы Necker Island-аас ментор хөтөлбөрийн дэмжлэг зөвлөгөө авч ажиллаж байна.
- 2015 онд “Их Британы Хамгийн Их Итгэл Хүлээсэн Бизнес Удирдагч” шагналын эзэн болж шалгарсан.
- 2015 онд Их Британы “Start Up Battle” уралдаанд TOP 10 шалгарсан.
- 2016 онд “International Coach of The Year 2016” Finalist шагналыг хүртсэн.
- 2017 онд “Мөнгөний Сэтгэлгээ 1.0”, “Гэр Бүлийн Динамик 1.0”, “Миний Бизнес” онлайн дасгалжуулалтын хөтөлбөрүүдээ гаргасан.
- 2018 онд Дасгалжуулалтын Академи ТББ маань үүсгэн байгуулагдсан.

МИНИЙ БИЗНЕС

“Миний Бизнес” бол жилд **60 хоног буюу 2 сарын хугацаанд** эрчимтэй суралцаж **, 2** жилийн туршид бизнесийнхээ хөгжлийн туршид хэрэгцээтэй дэмжлэгийг үзүүлэхэд зориулсан хөтөлбөр.

Монголд урьд нь хэн ч хийж байгаагүй цоо шинэ хэлбэрээр бэлтгэгдсэн дасгалжуулалтын хөтөлбөр юм.

Дасгалжуулалтын хөтөлбөрийн онцлог нь аль ч Бизнесийн удирдлагын баклавр, магистр, докторын сургалтанд суралцаад ч олж авч чадахааргүй **бодит амьдралд бизнест биеэр суралцдаг, сурсанаа биет үйлдэл хийж бизнесийнхээ зорилгыг хэрэгжүүлэх** хөтөлбөр гэсэн үг.

Та хөтөлбөртөө онлайнаар оролцоно. Та хэзээ завтай үедээ, хаа тухтай газраасаа, технологийн дэвшилтэт хэлбэрийг ашиглан, орон зайны давуу сэтгэлгээг дэлхийн нөгөө өнцөгт ашиглаж буй үнэ цэнэтэй мэдлэг туршлагаас цаг алдалгүй суралцан ажиллах гайхалтай боломжийг ашиглана.

Энд дарж онлайн хөтөлбөрийнхөө хуудас руу зочилно уу.



ХӨТӨЛБӨР ЮУГААРАА ДАВУУ ВЭ?

САЯТАН МЕНТОРУУДЫН АШИГЛАДАГ ШИЛДЭГ СТРАТЕГИУД

Энэ хөтөлбөрт дэлхийн саятан тэрбумтан шилдэг ментор бизнесменүүдийн хэрэглэдэг, олон зуун мянган ам долларын хөлстэйгөөр заадаг бүхнийг маш цөөн тооны азтай хүмүүст заах болно.

БИЗНЕСТ ХӨЛӨӨ ОЛОХ ХҮРТЭЛ 2 жилийн хугацаатай

Сургалтын бүх материал гарын авлага насан туршид таных болно. Та нэг удаа үзээд шууд хэрэгжүүлж чадахгүй байсан ч, жилээс жилд дахин дахин үзэж гардан бодит амьдралд тулгарч буй асуудал бэрхшээлүүдийг шийдэхэд тусална.

100% НАЙДВАРТАЙ ЭРСДЭЛ БАЙХГҮЙ ГАРАА ХӨДӨЛГӨСӨН БҮХ ХҮН АМАА ТОСДОНО

Суралцсан бүхнээ үр дүн гарган гаргатлаа үйлдэл хийхэд хангалттай 5 жилийн хугацааг танд бэлэглэж байна. 100% найдвартай. Тө зөвхөн онол суралцах бус, таны сэтгэлгээнд тулгарч буй бодит бэрхшээлүүдийг даван гарч сурах болно.

Танд бизнесийн мэдлэг огт байхгүй, бизнесийг ойлгодоггүй байсан ч бүх зүйлийг танд ойлгомжтой байж өөрийн болгож эзэмштэл нь туслан дэмжихээр хөтөлбөрөө бэлтгэсэн байгаа.

Таны бизнес цоо шинээр орчин үеийн технологи, дэлхийн зах зээлийн нөөц бололцоог оруулах хэрэгтэй бол энэ хөтөлбөр тусална.

Эдийн засгийн хямралтай энэ үед Монголын зах зээлд хамгийн эрэлт хэрэгцээтэй ҮНЭ ЦЭНЭ-тэй чухал бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний санааг олохоос авахуулаад, Монголд онцгой содон Брэнд бүтээх, тэдгээрийг хэрхэн зах зээлд хэрэгжүүлэх хэрэглэгчийн сэтгэлгээний философи ашиглаж маркетинг хийж сурах болно.

Онлайнаар бизнес хийх сонирхолтой боломжуудыг суралцах болно. Гайхалтай нь таны онлайн бизнес өдөр шөнөгүй, 7 хоногийн 24 цагийн туршид автоматаар таны төлөө ажиллах ид шидийг нь та нэг л өдөр харах болно. Онлайн бизнесүүд бол дэлхийг цаг наргүй өөрчилж буй машин л гэсэн үг. Гайхалтай!

ХӨТӨЛБӨР ЮУГААРАА ОНЦЛОГ ВЭ?

ДОЛОО ХОНОГ БҮРТ ШИНЭ МОДУЛЬ

Таны сэтгэлгээг цоо шинээр хөгжүүлж тэлэх гайхалтай чухал сэдвүүдийг хөндөж ярилцах болно. 8 модуль, маш энгийн атлаа гайхалтай увдистай арга стратегиуд танилцуулна.

ОНЛАЙН УУЛЗАЛТ ЧӨЛӨӨТ ЯРИЛЦЛАГУУД

Та дэлхийн хаанаас ч хамаагүй онлайн уулзалтаар хувийн амьдралынхаа ч, бизнесийн чухал асуултдаа хариулт авах, зөвлөгөө авах боломжтой. Боломжгүй зүйл гэж байдаггүй.

БИЗНЕСИЙН ЧУХАЛ АСУУЛТ ХАРИУЛТУУД

Та дэлхийд алдартай менторуудын мэдлэг туршлагыг Монголын зах зээл дээр хэрхэн нэвтрүүлэх талаар олон шинэ санаа хэрэгжүүлэх асуулт хариултуудыг хуваалцана.

ДИЖИТАЛ MULTIMEDIA ХЭЛБЭРЭЭР СУРНА

Хүний юм сурах арга барил янз янз. Ном унших, бичих, зурах, төсөөлөх, дүрслэх, сонсох, үзэх, биеэр барьж, мэдэрч хийх гэх мэт. Эдгээрийг бүгдийг нь ашиглаж хурдан сурах болно.

БАЙНГЫН ТУСЛАМЖ ДЭМЖЛЭГ

Энэ хөтөлбөрт оролцсон хүмүүс миний насан туршийн түнш хамт олон гэж нэрлэж болно. Бүх сургалтын материал бүтэн жил нээлттэй, жил бүр шинээр материал нэмэгдэх болно.

БАЯЛАГИЙН СҮЛЖЭЭ ENTREPRENEURS ХАМТРАГЧИД

Энэ хөтөлбөрт оролцож буй залуус Монголын зах зээлд цоо шинээр сэтгэдэг хийж бүтээдэг, Entrepreneur хамт олныг бий болгож хамтран ажиллах харилцаагаа эхлэх болно.

“МИНИЙ БИЗНЕС” ХӨТӨЛБӨР ХЭНД ТОХИРОМЖТОЙ ВЭ?

- Гарааны мөнгө их шаардахгүйгээр зөв бодлоготой бизнесээ эхлүүлэх хүн
- Ажлынхаа хажуугаар бизнесийн санаагаа хөгжүүлж, хөл дээр нь босгох зорилготой хүн
- Хувираа юм хийдэг хүн
- Хувийн бизнестэй болмоор байгаа хүн
- Хүүхдээ хараад гэртээ суух хоорондоо бизнес эхлүүлэх хүсэлтэй хүн
- Сурахынхаа хажуугаар өөрийн гэсэн бизнесийн санааг хөгжүүлэх хүсэлтэй оюутан
- Санхүүгийн эрх чөлөөнд хүрэхийг хүсч буй алсын бодолтой олон янзын бизнестэй хүн
- Хийсэн бүтээсэн юмтай байж, амжилтанд хүрэхийг хүссэн хүн
- Нийгэмдээ тодорхой байр суурьтай, нэр хүндтэй, тогтсон орлоготой, сэтгэл хангалуун амьдрахыг хүсч буй хүн
- Барилга, ресторан, зочид буудал, дэлгүүр, бөөны худалдааны бизнесээ тогворжуулж онлайн, технологийн нөөц бололцоог ашиглан, дараагийн түвшинд хөгжүүлэхийг хүсч байгаа хүн
- Бизнесийн нетворк, хамтран ажиллах, өргөжүүлэх боломж нөхцөл хайж байгаа хүн
- Хийж байгаа ажилдаа сэтгэл дундуур байгаа ч амьдралаа өөрчлөхийг зориглож цоо шинийг бүтээхээр эрэлхийлж байгаа хүн
- Уран бүтээлч, зохиолч, сэтгүүлч, найруулагч, дуулдаг, бүжиглэдэг, дизайнер, багш, үсчин, мужаан, барилгачин, IT инженер, гэх мэт ажил мэргэжилдээ дуртай түүгээрээ бизнес бүтээх хүсэлтэй хүн

ОРОЛЦОГЧДЫН СЭТГЭГДЭЛ

Мөнхжаргал
Оюутан, Тайван улс

“Миний Бизнес” хөтөлбөрт оролцохоосоо өмнө бизнес хийдэг хүмүүсийн ард нь зааж зөвлөдөг, спонсорлодог хөрөнгө оруулдаг ах дүү хамаатан садан байдаг байх, тийм болохоор тэд өнөөдрийн энэ амжилтандаа хүрсэн байх, надад тийм боломж бололцоо байхгүй болохоор бараг оролдоод ч хэрэггүй гэсэн бат итгэлтэй байдаг байсан. Мөн ямар нэгэн хийж эхлэхээр буруу хийчвэл яанаа, хүмүүс юу гэж хэлэх бол, ер нь бол юм болгон дээр хүн юу гээд хэлчих бол гэдгээс айдаг байлаа.

Би өөртөө маш итгэлтэй болсон, өөрөөр хэлбэл сэтгэлгээ маань хамаагүй өөр түвшинд сэтгэж бодож чаддаг болж байна, өөрөө өөртөө өгөөд байдаг байсан сэтгэлгээний блокуудаа арилгаж чадсан. Ямар нэгэн зүйлээс айгаад сүрдээд өөрөө жижгэрээд суух биш оролдоод хийгээд суралцаад ирвэл, илүү нарийн жижиг жижиг хэсгүүдэд хуваагаад нягтлаад харвал бид өөрсдөө учрийг нь олоод асуудлуудаа шийдээд явж болдог юм байна. Бизнес гэдгийг илүү өргөн утгаар харж, өөртөө байгаа боломж бололцоогоо ашиглаж өөрийн болоод бусад хүмүүст хэрэгтэй асуудлыг шийдэхэд бизнесийн нууц оршдог юм байна. Одоо нөгөө юун бизнесээс айж сүрдээд байсан хүн өөрийн бизнес санаагаа олоод хэрэгжүүлэх бэлтгэл ажилдаа ороод явж байна. Хичээлийнхээ дагуу дасгал ажиллаад ирэхээр нэг л саарал ерөнхий байгаад байсан зүйл маань маш гоё системд орж юу хийх вэ гэдэг маань тодорхой болоод ирж байна.

“Миний Бизнес” хөтөлбөрт орохоосоо өмнө би бизнес хийж чадах эсэхтээ эргэлзсэн өөртөө итгэлгүй нэгэн байсан. Харин хөтөлбөр дуусахад миний анзаарсан юм бол өөртөө их итгэлтэй болсон байсан. Бизнесээ амжилттай эхлүүлж чадсан. Боломж байгааг анзаарч харж эхэлж , урам зоригтой итгэлтэй болсон. Хүмүүсийн сэтгэлгээг өөрчилсөнөөр сургалтанд суусан хүмүүс 2-хон сарын дотор ямар гайхалтай өөрчлөгдөж амжилттай хүрч байгаа нь надад ид шид шиг санагдсан. Миний сэтгэлгээ маш их өөрчлөгдсөн. Хүнтэй харилцах харилцаанд болон бизнесээ хийх дээрээ маш олон амжилтууд гаргаж байгаа. Сэтгэл маш өндөр байгаа. Энэ сургалтанд сууснаар өөрийгөө маш азтай нэгэнд тооцож байгаа. Өөрийгөө шинээр нээж олж харсан. надад амжэилтанд хүрэхэд маш олон боломжууд байгааг анзаарч харсандаа маш их баяртай байгаа. Моника болон түүний байгынханд маш их талархаж байгаа. Би өөрчлөгдөөд ирэхээр нөхөрт маань хүртэл эерэгээр нөлөөлж, бидний дунд амжилт боломжийн тухай яриа их өрнөдөг болсон. Оролцож амжаагүй байгаа хүмүүст захиахад, “Эргэлзэх хэрэггүй ээ, энэ сургалтанд цаг алдалгүй суугаарай” гэж хэлмээр байна.

А. Оюунзул
УБ, Монгол

ОРОЛЦОГЧДЫН СЭТГЭГДЭЛ

Н. Цэцэгханд
Барселон, Испани

So, I never thought of myself that I am a person that could achieve something like starting a micro business. I always was thinking, those people are so different type of people than myself. As people who graduated financial science or MBA. People like sportmen, who are very ambitious. Who am I? Just a normal person who wants to enjoy my life. But working in a office 9:00-18:00 was never making me happy, just seldom achieve some professional goals yes. By curiosity I joined this course and I am glad I had that chance, that idea came to my mind in the last moment and applied to this course.
My life changed a lot since the halfway through this course. I understood that each person has own talent and can use it to make a business. Authentic business. and also that there are so many business types that can be connected to the person's lifestyle too. Before I was thinking only the beautiful cute girls do that in Instagram. I also understood I have to step out of my confort zone and do the first step forward to my dream, not waiting for someone powerful come to me and give me that dream. This course also tought lot of techniques that we can use for building online business. What influenced me is to think above the level of worker. Be caurageous to make first step. To create website. This is a great program especially for Mongolian people who not only lack English language knowledge, but also and importantly lack confidence in themselves and are so tied to steoretypes of the Mongolian society, Monica has a long experience working with Mongolian people and helping them to change their mindset. I already told many people about this program and that should get this course next year.

Би төрийн байгууллагад олон жил ажилласан, их завгүй, ажлынхаа ачаалалд дарагдаад хааяа цаг наргүй ажилладаг байсан. Сүүлдээ юуны төлөө амьдраад байгаагаа мэдэхгүй байж байхдаа “Миний Бизнес” хөтөлбөрт орж ирсэн. Тэр үед би өөртөө итгэлгүй, ямар ч бизнес хийх санаагаа олоогүй орж ирсэн. Харин удахгүй онлайн уулзалтаар группээрээ яриад ирэхээр зөндөө олон шинэ санаатай болоод бүх юм боломжтой юм шиг санагддаг болсон. Намайг хүмүүс их өөрчлөгдсөнийг гайхаж байсан. Бизнесийн санаагаа олсон, яаж хийх аргаа ч ойлгож авсан. Амьдралын түүх таалагдсан үүнд өөрийн дуртай зүйлээ олсон. Үүнийгээ бизнес санаагаа дуртай зүйлтэйгээ холбож чадсан гэж дүгнэж байна. Дасгалууд, болон өөрийн бизнес санаагаа олсон хүн тэр бизнес санаагаа хичээлтэйгээ холбоод хийгээд байх нь чухал үр дүнтэй байгааг мэдэрсэн. Би энэ хөтөлбөрүүд үр дүнтэй үр өгөөжтэй гэдгийг мэдэрсэн энэ хөтөлбөртөө орсондоо баярлаж явдаг. Бусад хүмүүст үүнийгээ хэлдэг санал болгодог. Хүмүүст захих юм гэвэл, “Хугацаа алдалгүй үйлдэл хийгээрэй, ямар нэгэн зүйлийг хүлээж суух биш энэ хөтөлбөрүүдэд л хамрагдаарай гэж үр дүнг мэдэрсэн хүний хувьд хэлж байнаа.”

Б. Байгалмаа
УБ, Монгол

ЭНЭ ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ ЮУ ВЭ?

- Монгол хүний сэтгэхүй, бүтээлч чадварыг хөгжүүлэхэд зориулж байна.
- Монголын нийгэмд тулгарч буй Бэрхшээлүүдийг шийдэх зөв бодлоготой бизнесүүдийг бүтээхэд зориулж байна.
- Монгол хүний чадвараар ҮНЭ ЦЭНЭ-тэй бараа бүтээгдэхүүн боловсруулах, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж сурахад зориулж байна.
- Монгол хүний сэтгэхүйн онцлогт тохирсон үр өгөөжтэй маркетингийн арга барилыг ойлгож ашиглаж сургахад зорьж байна.
- Монголын бүтээлч чадварлаг залуусын дэлхийн зах зээл дээр нэвтрэхэд суурь нөөц бололцоо, сэтгэхүйн чадварыг хөгжүүлэхэд зорьж байна.
- Санхүүгийн бие даасан чадвартай тогтмол орлоготой өөртөө итгэлтэй удирдах чадварлаг залуусыг бий болгоход зорьж байна.
- Мэдлэг боловсролыг бодит амьдрал руу ойртуулж мөнгөн орлого олох чадварыг ахиулахын төлөө чиглэн ажиллаж байна.
- Гарааны мөнгөгүйгээр эсвэл маш бага мөнгөөр бизнес эхлүүлэх боломжуудыг түгээн нэвтрүүлж байна.

ЭНЭ ХӨТӨЛБӨР

1. ТАНД
2. ТАНАЙ ГЭР БҮЛД
3. МОНГОЛЫН НИЙГЭМД

ЯМАР ҮР ӨГӨӨЖТЭЙ ВЭ?

- Эдийн засгийн хямрал цаашдаа улам л муудаж, өсөлт удаашрах чиг хандлагатай байгаа. Баян ядуугийн ялгаа Монголд ихэссээр л байна. Таныг, тухайлбал мөнгө олох чадваргүй, бизнесийн нөхцөлөө бүрдүүлж чадаагүй хүмүүсийг, амьдралын, бизнесийн арга чадвартай болгоход энэ хөтөлбөр төвлөрч ажиллаж байгаа.
- Техник технологийн хөгжил таныг өнөөдөр байгаагаасаа илүү хурдацтай авхаалжтай сэтгэхийг шаардаж байна. Үүнтэй зэрэгцэн алхах цорын ганц хурд бол Бизнес. Онлайн бизнес, технологийн давууг ашиглаж сурах ур чадварыг эзэмшүүлэх болно.
- Одоогийн төрийн тогтолцоо будилаантай бодлогын байдлаас харвал Монгол хүн бие даасан чадвартай байхыг шаардаж байна. Биеэ зас, гэрээ зас, төрөө зас гэдэг, бид энэ дарааллаар таныг хөгжүүлж, гэр бүлээ санхүүгээр хангах чадвар олгож, нийгмээ, төрөө тогтвортой хөгжих эх үүсвэрийг нь тавих болно.
- Ажлын байр тогтворгүй, цалин хангалтгүй тул таныг ажлаас гадуур орлогын эх үүсвэртэй байхыг улам тодоор сануулсаар л байна. Хувиараа бизнес эрхлээд өөрийн гэсэн тогтмол орлоготой болж сургах зорилготойгоор энэ хөтөлбөр бэлтгэгдсэн.
- Өвчин зовлон хэнийг ч тойрохгүй ирдэг, харамсалтай нь монголын эрүүл мэндийн салбар таны болон танай гэр бүлийн өвчин зовиурыг эдгээж чадах найдвар тун бага болоод байна. Гадаад руу гарч эмчилгээнд явахад мөнгөний асуудал хамгийн том. Тэгвэл энэ хөтөлбөр таны өмнө хэзээ ч ирж болзошгүй тэр хүнд ачааллыг давж гарахад бас санхүүгийн айдас аюулгүй орчин бүрдүүлнэ гэдэгт найдаж байна. Та тогтмол сайн орлоготой болчихвол гэр бүлийнхнээ өвчин зовлонгоос аврах гайхалтай давуу нөхцөлд амьдрах болно.
- Валютын ханш жилээс жилд өсч, Монгол төгрөгний ханш буурч байгаа өнөө үед гадаадаас импортын бараа оруулж ирэх нь Монголын нийгэмд улам л сөргөөр нөлөөлж байна. Импортыг багасгах цорын ганц арга бол Монгол Бизнес бүтээх.
- Чадварлаг Монгол залуус, зөв бодлоготой удирдагчид дутагдсаар л байна. Энэ хөтөлбөр яг ийм чадварлаг ухаалаг удирдагчдийг хөгжүүлнэ.
- Та яаж амьдарна таны хойч ирээдүй үр хүүхэд тийм л орчинг танаас өвлөн үлдэнэ. Үр хүүхдүүд таныг дуурайх болно. Монголын ирээдүйг таны чадварын ачаар аварна.
- Бизнес бол зөв замаар Монголыг бүтээх цорын ганц арга зам. Монгол брэнд, Монгол Үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлэхэд хэрэгцээтэй ур чадварыг олгохийн төлөө энэ хөтөлбөр ажиллаж байна.

ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

Танилцуулга. Сюрприз уулзалт	**09 сарын 06-нд** 18 цаг (УБ цаг)
Сэтгэл доглом ярилцлага студи уулзалт	**09 сарын 02-ноос 05-ны хооронд**
Модуль нэг. Миний Амьдрал Диамонд	**9 сарын 13-нд** 18 цаг (УБ цаг)
Модуль хоёр. Миний Бизнесийн Загвар Модель	**9 сарын 20-нд** 18 цаг (УБ цаг)
Модуль гурав. Миний Бизнесийн Зах Зээл	**9 сарын 27-нд** 18 цаг (УБ цаг)
Модуль дөрөв. Миний Вэбсайт Онлайн Бизнес Машин	**10 сарын 04-нд** 18 цаг (УБ цаг)
Модуль тав. Миний Бизнесийн Харилцаа	10 сарын 11-нд 18 цаг (УБ цаг)
Модуль зургаа. Миний Бизнесийн Бүтээгдэхүүн	10 сарын 18-нд 18 цаг (УБ цаг)
Модуль долоо. Миний Бизнесийн Маркетинг	10 сарын 25-нд 18 цаг (УБ цаг)
Модуль найм. Миний Бизнесийн Төлөвлөгөө	11 сарын 01-нд 18 цаг (УБ цаг)
Төгсөлтийн баяр онлайн уулзалт	11 сарын 08-нд 18 цаг (УБ цаг)
Сэтгэл доглом ярилцлага студи уулзалт	11 сарын 09-нөөс 15-нд

БОНУС. ТАНД ЗОРИУЛСАН ОНЦГОЙ БЭЛГҮҮД

“МИНИЙ БИЗНЕС” хөтөлбөртөө дахин **оролцох эрх 1 жил** Үнэ**5**6 сая ₮

“МИНИЙ БИЗНЕС” ФЭЙСБҮҮК ГРУППТ ТАВТАЙ МОРИЛ

Хөтөлбөрийн маань бүх оролцогчид “Миний Бизнес” файсбүүк группт уригдаж байгаа бөгөөд энэ групп дотроо ямарваа нэгэн хувийн асуултаа бичиж, бие биентэйгээ танилцаж, өөрийн ололт амжилтыг чөлөөтэй хуваалцаж байгаарай.

Энэ линкийг дараад групптээ нэгдээрэй.

Бид чинь хамтдаа 5 жилийнхээ бизнесийн туршлага, мэдлэгээ суралцаж, хамтран алдаж босч, баялгийн сүлжээгээ эндээс хүчирхэгжүүлж байгаа шүү дээ. Групп дотроо чөлөөтэй харилцаж, асуулт байвал мэдэгдэж ярилцаж байгаарай.

ОНЛАЙН УУЛЗАЛТАНДАА ОРОЛЦОХ ТЕХНИКИЙН ЗААВАРЧИЛГАА



Zoom application татаж суулгах. Энд дарж Zoom аппликэшнээ татаж аваарай.
Та гар утас, таблет, компютер дээр аль алин дээр нь энэ аппликэшнийг үнэгүй татаж аваад суулгаарай.

Онлайн уулзалтанд оролцох
Zoom Application Meeting ID: 595-159-216

Онлайн уулзалтанд оролцох. Онлайн уулзалтанд оролцох линкийг бид имэйлээр илгээх болно. Имэйлээр илгээсэн линкээрээ Meeting ID ашиглаад оролцоорой.

ОНЛАЙН УУЛЗАЛТ БОЛОХ ҮЕД

Биеэр оролцох. Онлайн уулзалтанд оролцоход таны интернетийн холбоос сайн, вэб камер ажиллагаатай, микрофон ажиллагаатай байвал танд асуулт гарахад биетээр асуух боломж гарахад танд арай боломжтой болох байх. Онлайн уулзалтанд оролцох үед намайг ярьж асуултанд хариулах үед аль болох өөрийн микрофоныг хааж, ярих үедээ л зөвхөн нээвэл онлайн уулзалтын видеонд ч бас дуу шуугиан байхгүй цэвэрхэн сонсогддог давуу тал бий. Би таныг иймэрхүү тал дээр мэдрэмжтэй хандана гэдэгт итгэлтэй байна.

Асуулт асуух. Бүх онлайн уулзалтууд чөлөөтэй асуулт хариултаар, бизнесийн бэрхшээлүүдийг тань шийдэх хамгийн чухал үнэ цэнэтэй үе байдаг. Бусад оролцогчдоосоо бүү нэрэлхээрэй. Нэрэлхээд та хожихгүй. Таны асуултууд таны гарах гарцыг боломжийг олж авахад тусална. Бусад оролцогчид ч таны нөхцөл байдлыг ойлгох тусмаа танд тусалж дэмжиж хамтран ажиллах санал тавих нь элбэг бий. Тиймээс зоригтой байгаарай.

Онлайн уулзалт давтан үзэх. Бид онлайн уулзалт дуусмагц модуль тус бүрийнхээ онлайн уулзалтын видео бичлэгийг давтан үзэх боломжтойгоор энэ линкэн дээр байрлуулах болно. Тиймээс та модулиудаа хэдэн ч удаа давтан үзэж болно.

ОНЛАЙН УУЛЗАЛТАНДАА ОРОЛЦОХ ТАЛААР

Модулиудын онлайн уулзалтууд хэдэн цаг үргэлжлэх вэ?

- Онлайн уулзалтууд Ням гаригт 18 цагт (УБ цагаар) эхлээд ойролцоогоор 6-8 цаг үргэлжилдэг. Оролцогчдынхоо асуултанд хариулт өгч, чөлөөт ярилцлага өрнүүлдэг. Манай оролцогчид энэ завшааныг ашиглаж бие биенийхээ бизнесийг ойлгох, дэмжих хамтдаа санаа оноогоо хуваалцаж ярилцдаг тул энэ ярилцлагууд их сонирхолтой болдог. Тиймээс оролцохдоо удаан суух бэлтгэлтэй цагаа зохицуулж орж ирээрэй.

Гадаадаас оролцох тохиолдолд яаж оролцох вэ?

- Та онлайн уулзалтынхаа цагийг өөрийн амьдардаг улс хотын цагийн хуваарьтай **worldtimebuddy.com** ашиглан олж цагийн хуваариа зохицуулаарай.

Онлайн уулзалтандаа оролцож амжихгүй эсвэл хоцрохоор бол яах вэ?

- Бид онлайн уулзалт дуусмагц модуль тус бүрийнхээ онлайн уулзалтын видео бичлэгийг давтан үзэх боломжтойгоор вэбсайт дээрээ байрлуулах болно. Тиймээс та модулиудаа хэдэн ч удаа давтан үзэж болно.

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТУУД

Хөтөлбөрийн дасгалууд яагаад хийх ёстой вэ?

- Би таны тархинд байгаа мэдээллүүдийг бүгдийг нь мэдэхгүй. Дасгалууд таны оюун ухаанд байгаа мэдээллүүдийг бизнестээ ашигтайгаар хөрвүүлж гаргаж ирэхэд тань зориулсан. Дасгалдаа сайн анхаарлаа төвлөрүүлж хийх тусмаа бизнесийнхээ чухал амжилт гаргах санаагаа та олж авах болно.

Дасгалынхаа хариултыг хариулж мэдэхгүй байвал яах вэ?

- Дасгалынхаа хариултыг мэдэхгүй бол өөрөөсөө асуугаад тэр асуудал дээр илүү тодорхой судалгаа мэдээлэл олох зорилгоор өөрийгөө хөгжүүлж ажиллаарай. Та хэр сайн анхаарлаа төвлөрүүлнэ, тэрний хэмжээгээр хариултаа олж чадна.

Дасгалаа ажиллах цаг зав гарахгүй бол яах вэ?

- Та цагийн менежментээ сайжруулж хөтөлбөрийнхөө хөрөнгө оруулалтанд утга учир өгөх тусмаа дэмий зүйлд зориулах цаг зав байхгүй маш богино хугацаанд үр дүнгээ гаргаж чадалтай болно. Та цаг заваа зориулж өөрийгөө дайчлахаас нааш таны бизнесийг хэн ч аварч чадахгүй гэдгийг санаарай.

ХӨТӨЛБӨРӨӨ ЯАЖ УР ӨГӨӨЖТЭЙ БОЛГОХ ВЭ?

СЭТГЭЖ ЧАДНА ГЭДЭГТЭЭ ИТГЭ

Хөтөлбөрийн гол зорилго бол та өөрөө сэтгэж, өөртөө найдаж сурах явдал. Танд зөв замыг та л олж харах ёстой. Таны тархинд хангалттай бүх мэдээлэл байгаа гэдэгт итгэ.

АНХААРЛАА ТӨВЛӨРҮҮЛ

Олон юманд бүү санаагаа зовоо. Бүү мэдэмхийр. Энэ л амьдралын тань ирээдүйг шийдэх юм шиг л амьсгаа даран анхаарлаа төвлөрүүл. Төвлөрсөн хүн сэтгэдэг.

ТЭМДЭГЛЭЛ ХИЙ

Хүн бүхэн мартдаг. Оюун ухаанаараа боловсруулж тэмдэглэл хий. Амьдралдаа анхаарах хэрэгжүүлэх зүйлсээ, ойлгосоноо өөрийн үгээр, зургаар, амьдруулж тэмдэглэ.

ЦАГТ НЬ АМЖУУЛ

Цагт нь дасгалаа хий, асуултаа явуул, өөртэйгөө тулж ажилла, дасгалжуулалт модуль болгон дээрээс сурсанаа хэрэгжүүлэх арга хай. Хүн болгон завгүй. Бүү шалтаг тооч. Амжуулж сурсан хүнд л амжилт ирнэ.

ДАСГАЛАА АЖИЛЛА

Хийгээгүй хүн хэлэх үггүй, бусдын заасныг дагадаг. Дасгал таны сэтгэлгээг тэлэх ёстой. Дасгалаа үнэнчээр ажиллаад ирсэн хүн байнга цоо шинэ асуулттай орж ирдэг. Энэ бол сэтгэхүйн өсөлт.

АЛХАМ ХИЙ

Монголд ийм сэтгэлгээгээр ажиллаж амьдардаг хүмүүс маш цөөн. Тэр цөөнхийг та бид хамтдаа бий болгох бөгөөд алсдаа Entrepreneurs бүтээлч найзуудтай хамтран сэтгэх боломжтой.

ХӨТӨЛБӨРӨӨ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАНЫ 15 ШИНЭ ДАДАЛ

1. БЭРХШЭЭЛЭЭ ОЙРТОЖ ХАР
2. СӨРӨГ БОДЛЫГ ЭЕРЭГ БОЛГОЖ АШИГЛА
3. ЯДУУ СЭТГЭЛГЭЭНЭЭС БОЛГООМЖИЛ
4. ЭРҮҮЛ ЧИЙРЭГ АМЬДРАЛЫГ ӨӨРТӨӨ СОНГО
5. БУСДЫН НӨЛӨӨНД БҮҮ АВТ
6. АНГЛИ ХЭЛИЙГ ЧӨЛӨӨТЭЙ АШИГЛА
7. ЦАГ ЗАВАА ЗӨВХӨН ЧУХАЛ ЗҮЙЛД ЗОРИУЛ
8. МӨНГӨНД ТООЦООТОЙ ХАНД
9. МЭДЛЭГ ТУРШЛАГАА ХӨГЖҮҮЛ
10. ТЕХНИК ТЕХНОЛОГИ АШИГЛАЖ СУР
11. ӨӨРӨӨСӨӨ АСУУЛТ АСУУЖ ХАРИУЛТАА ОЛ
12. ӨӨРИЙГӨӨ БУСАДТАЙ БҮҮ ХАРЬЦУУЛ
13. ӨӨРИЙГӨӨ ХАЙРЛА
14. ЗОРИЛГОДОО АНХААРЛАА ТӨВЛӨРҮҮЛ
15. ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЖ СУР

“МИНИЙ БИЗНЕС” ХӨТӨЛБӨРИЙНХӨӨ ТАНИЛЦУУЛГА СЮРПРИЗ УУЛЗАЛТАНД ОРОЛЦОХ ТАНЫ БЭЛТГЭЛ

Ярихдаа бүү санаа зовж нэрэлхээрэй. Бид таныг болон таны бизнесийн бодит байдал ололт амжилт, бэрхшээлийг л ойлгож дэмжих гэж уулзаж байгаа гэдгийг санаарай. Хэлэхгүй бол танд тусалж чадахгүй.

ТАНЫ МЭРГЭЖИЛ, ТУРШЛАГА, АМЬДРАЛЫН ТҮҮХ, АЛДАА

Таны туулж амьдарсан бүхэн таныг цаашдаа хаашаа явах зүг чигийг тодорхойлж, мэргэн ухаан суулгаж байдаг. Амьдралынхаа бэрхшээлийг ч бидэнтэй хуваалцахад бэлэн байгаарай.

ТАНЫ “МИНИЙ БИЗНЕС” ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОХ БОЛСОН ШАЛТГААН

Хүн болгоны бизнес хийх шалтгаан өөр өөр. Таныг бизнес хийхгүй л бол болохгүй байгаа, таныг бизнес хийж байж л өөрчлөхийг хүссэн тэр бүхнээ хуваалцана уу.

ТАНЫ БИЗНЕСИЙН САНАА, ОДООГИЙН БАЙДАЛ ЗОРИЛГО

Таны өнөөгийн бизнесийн нөхцөл байдал санаа зорилго юу вэ? Бизнесийн санаа эсвэл бизнесгүй байсан ч ямар хүсэлтэй тэмүүлэлтэй байгаагаа яриарай.

ТАНЫ ЭНЭ ХӨТӨЛБӨРТ ОРООД НЭН ТЭРГҮҮНД ШИЙДЭХИЙГ ХҮСЧ БУЙ 3 ЗҮЙЛ

Та энэ хөтөлбөрт зорилготой орж ирсэн. Таныг энэ хөтөлбөрт орж ирсэнээр хамгийн түрүүнд хариулт олж авах хэрэгтэй байгаа 3 бэрхшээлийг та дурьдаж бидэнтэй хуваалцана уу.



ХӨТӨЛБӨР НЭЭГДЭХ ӨДӨР:
09 САРЫН 01

СЭТГЭЛ ДОГДЛОМ СТУДИ ЯРИЛЦЛАГА ХИЙХ ӨДӨР, УУЛЗАХ ГАЗАР:

ХӨТӨЛБӨРИЙНХӨӨ ВЭБСАЙТНААС ХАРНА УУ.

ХӨТӨЛБӨРИЙН НЭЭЛТ

СЭТГЭЛ ДОГДЛОМ ЯРИЛЦЛАГА СТУДИ УУЛЗАЛТ

Бид жил бүр оролцогчдоо сэтгэл догдлом энэ гайхалтай мөчөөр дамжуулан уулзалдаж ид шидийн ертөнц рүү алхахаасаа өмнө нэгэн гоё сюрприз уулзалтыг хийдэг. Энэ уулзалт бол таныг өөрөө өөртөө зориулж хөрөнгө оруулалт хийсний бэлэг тэмдэг, таны амьдралын одоогийн нөхцөл байдал, сэтгэлгээний түвшин цар хүрээг бид эргэн харахад тань дурсамж болгох зорилгоор бэлтгэгддэг.
Энэ өдөр та манай багийн залуусын зохион байгуулсан бичлэгийн студид хүрэлцэн ирэх бөгөөд чин сэтгэлээсээ ярилцлага өгөх юм. Энэ яриа зөвхөн таны өөрчлөлтөнд зориулж асуугдах бөгөөд бид яг энэн шиг студийн ярилцлагыг хөтөлбөрийн төгсгөлд төгсөлтийн баяраар тохиолдуулж хийх болно. Энэ 2 ярианы хооронд та хэрхэн өөрчлөгдсөнөө харах зориулалттай.

ТАНЫ БЭЛТГЭЛ
Таныг яг одоогоор тодорхойлж болох бүхнийг илэрхийлээрэй.
Таалагддаг хувцсаа өмс, өөрөөрөө байгаарай. Энэ бол ид шидийн эхлэл.

ХҮСЭЛ МӨРӨӨДӨЛ БАЙДАГ УЧРААС БЭРХШЭЭЛ СҮҮДЭР ШИГ ДАГАДАГ, ЗОРИЛГОДОО ХҮРЭХИЙН ТУЛД АМЖИЛТ НҮДЭНД ХАРАГДДАГ УЧРААС БОЛОМЖ ӨМНӨ НЭЭГДДЭГ.
АМЬД ЯВАА ХҮН БҮРТ **БЭРХШЭЭЛ БА БОЛОМЖ** ИРЭЭДҮЙ БОЛОН ҮЗЭГДЭЭД, ӨНГӨРСНӨӨ САНАХ ТҮҮХ БОЛОН БИЧИГДДЭГ.

- МОДУЛЬ 1 -

МИНИЙ АМЬДРАЛ ДИАМОНД

МОДУЛЬ НЭГ.

МИНИЙ АМЬДРАЛ ДИАМОНД

ОНЛАЙН УУЛЗАЛТЫН ӨДӨР:
09 САРЫ 13 НЯМ 18 ЦАГ
(УБ ЦАГААР)

Онлайн уулзалтанд оролцох
Zoom Application Meeting ID
595-159-216

МОДУЛЬ НЭГ.

МИНИЙ АМЬДРАЛ ДИАМОНД

Таны амьдралд юу тохиолдож, хаагуур юу туулж, юу сурч, юунд харамсаж, юуны төлөө өдийг хүртэл явж ирсэнийг танаас өөр хэн ч мэдэхгүй. Өнгөрсөн амьдралынхаа алдаанаасаа ирээдүйгээсээ айж бэрхшээж, тойрч будилж амьдрахыг хүсэх нэг ч хүн байхгүй. Та амжилтаа баталгаажуулж цаашид хөгжихийг та эрмэлзэж байгаа.

БЭРХШЭЭЛ айдас таныг бүрхээд байвал яах вэ? Энэ модуль таныг өнгөрсөн амьдралын алдаа, харамсалаас тань чөлөөлж, үнэний толинд өөрийгөө олж харж цоо шинээр үнэ цэнэтэй Диамонд мэт гялалзан амьдрах өөртөө итгэх итгэлээ олж авахад тань туслах болно.

Ингэснээр та суусан газраасаа шороо атгах мэт амьдралын агуу ухаанаас суралцах хөтөлбөрийнхөө анхны гараагаа хийх болно. Энэ модуль бол таны эрх чөлөөний босгоор алхахад тань урих болно.

//
ШҮҮМЖЛЭХ, УУРЛАЖ БУХИМДАХ, ДҮРГҮЙЦЭХ, ХАРАМСАХ НЬ ХҮНИЙ БИЕ МАХБОДИД ХАМГИЙН ИХ ӨВЧИН ЗОВИУР АВЧИРДАГ

LOUISE HAY

- МОДУЛЬ 2 -

МИНИЙ БИЗНЕСИЙН ЗАГВАР МОДЕЛЬ

МОДУЛЬ ХОЁР.

МИНИЙ БИЗНЕСИЙН ЗАГВАР МОДЕЛЬ

ОНЛАЙН УУЛЗАЛТЫН ӨДӨР:
09 САРЫН 20 НЯМ 18 ЦАГ
(УБ ЦАГААР)

Онлайн уулзалтанд оролцох
Zoom Application Meeting ID:
595-159-216

МОДУЛЬ ХОЁР.

МИНИЙ БИЗНЕСИЙН ЗАГВАР МОДЕЛЬ

Энэ бол цоо шинэ бизнесийнхээ ирээдүйг сонгож амьдралынхаа дизайныг бодитоор зураглаж бий болгох гайхалтай цаг. Энэ модуль дээр амьдралаасаа урган гарсан үнэ цэнэтэй Диамондыг зөвхөн танд тохирсон бизнесийн загвар модель болгож хувиргахад зориулагдсан.

Миний энд танд зориулж сонгосон Бизнесийн загвар бүтээх арга бол өнөөдөр дэлхийн олон сая Entrepreneur-иудыг бизнесийнхээ бүрэн эзэн байхад нь тусалж гайхалтай бүтээлч, ажил хэрэгч Бизнесийн эзэн болоход тань нөлөөлнө.

Энэ модуль таны бүх бодол мөрөөдлийг цаасан дээр буулгаж өгнө.

//

БИЗНЕСИЙН ЗАГВАРАА НЭГ Л ОЙЛГООД АВЧИХВАЛ, НИЛЭЭН ОЛОН ХУВИЛБАР БИЙ БОЛГОЖ ЭХЛЭХ БОЛНО.

ALEXANDER OSTERWALDER



- МОДУЛЬ 3 -

МИНИЙ БИЗНЕСИЙН ЗАХ ЗЭЭЛ

МОДУЛЬ ГУРАВ.

МИНИЙ БИЗНЕСИЙН ЗАХ ЗЭЭЛ

ОНЛАЙН УУЛЗАЛТЫН ӨДӨР:
09 САРЫН 27 НЯМ 18 ЦАГ
(УБ ЦАГААР)

Онлайн уулзалтанд оролцох
Zoom Application Meeting ID:
595-159-216

МОДУЛЬ ГУРАВ.

МИНИЙ БИЗНЕСИЙН ЗАХ ЗЭЭЛ

Зах зээлийн судалгаагаа хийгээгүй эсвэл хийсэн судалгаа нь үр дүн муутай учраас бизнесүүд ашиггүй ажилладаг.

Үйлчлүүлэгчийнхээ, хэрэглэгчийнхээ эрэлт хэрэгцээ сонирхлыг бодолцохоосоо өмнө бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулах нь тухайн бүтээгдэхүүн борлогдохгүй маркетинг хийхэд үнэхээр хэцүү байх аюултайгаас гадна, санхүүгийн асар олон сая төгрөгний гарз хохирлыг авчирдаг.

Зах зээлийн судалгаа хийдэг төлбөртэй үйлчилгээнүүд ч жинхэнэ утгаараа зах зээлийн судалгааг гаргаж ирэхдээ хэт ерөнхий, статистик үзүүлэлт төдий гаргадаг учир, бизнесүүд түүнийг нь ашиглаж үр дүнтэй бизнесийн ашигтай ажиллаж чаддаггүй. Энэ модуль таныг өөрийн бизнесийнхээ зах зээлийн жинхэнэ байр суурийг таньж ашиг орлоготой эрэлт хэрэгцээг танихад асар их түлхэц өгөх болно.

//

САНАМСАРГҮЙ ЯВДЛУУДЫГ ХҮЛЦЭН ТЭВЧИЖ АМЬДРАХ БИШ,
САНААТАЙГААР АМЬДРАЛАА ЗОХИО

- МОДУЛЬ 4 -

МИНИЙ ВЭБСАЙТ

ОНЛАЙН БИЗНЕС МАШИН

МОДУЛЬ ДӨРӨВ.

МИНИЙ ВЭБСАЙТ ОНЛАЙН БИЗНЕС МАШИН

ОНЛАЙН УУЛЗАЛТЫН ӨДӨР:
10 САРЫН 04 НЯМ 18 ЦАГ
(УБ ЦАГААР)

Онлайн уулзалтанд оролцох
Zoom Application Meeting ID:
595-159-216

МОДУЛЬ ДӨРӨВ.

МИНИЙ ВЭБСАЙТ ОНЛАЙН БИЗНЕС МАШИН

Та ямар ч амжилттай том бизнестэй бай, онлайнаар бизнес хийхгүй бол удахгүй зах зээлээ алдана. Онлайн бизнес машин таны хэрэглэгчийн сэтгэлгээ, эрэлт хэрэгцээтэй зэрэгцэн алхаж, таны бизнесийн маркетингийн хэрэгсэл болохоос гадна, борлуулалтын асар хүчтэй сувгийн нэг болоод байгаа.

Энэ модульд таныг вэбсайт яаж хийх талаар анхан шатны мэдлэггүй хүн ч ойлгохоор амархан хурдан аргуудыг бие дааж хийж сурахад үе шаттайгаар зааж өгнө. Вэбсайтаа сайн мэдэж ойлгодог байх нь танд хянах эрх мэдэл, мөнгө, цаг, хөлс хүч хэмнэх болно. Вэб хөгжүүлэгч, бизнес эрхлэгчдийн хооронд гардаг олон бэрхшээлийг та шийдэх чадвартай алсын хараатай удирдагч болох гарааг эндээс эхлэх болно. Глобал зах зээлд outsourcing хийх гайхалтай нөөц боломжуудыг олж нээж ашиглаж сурна.

Энэ модуль таныг компьютер техникийн ажлаас айхгүй бүтээж сургах болно. Энэ модуль дангаараа таны 5 сая төгрөгний хөрөнгө оруулалтыг хэмнэнэ.

//
АМЛАСАН АМЛАЛТЫН ХЭМЖЭЭ АМЬДРАЛЫН ХЭМЖЭЭГ ТАНЬ ТОДОРХОЙЛДОГ.

ROGER JAMES HAMILTON

- МОДУЛЬ 5 -

МИНИЙ БИЗНЕСИЙН ХАРИЛЦАА

МОДУЛЬ ТАВ.

МИНИЙ БИЗНЕСИЙН ХАРИЛЦАА

ОНЛАЙН УУЛЗАЛТЫН ӨДӨР:
10 САРЫН 11 НЯМ 18 ЦАГ
(УБ ЦАГААР)

Онлайн уулзалтанд оролцох
Zoom Application Meeting ID:
595-159-216

МОДУЛЬ ТАВ.

МИНИЙ БИЗНЕСИЙН ХАРИЛЦАА

Монголчуудын маань хамгийн их гаргадаг алдаа бол харилцааны асуудал. Гэр бүлийн хүмүүсийн хооронд ч, найз нөхдийн хооронд ч харилцааны асуудлаас болж асар их будилаан зөрчилдөөн, хэрүүл маргаан гардаг. Харамсалтай нь харилцааны аргаа олж авч суралцаагүй ийм бизнесийн хүмүүс маань бизнес хийхээрээ улам том харилцааны шаардлага сорилттой тулгардаг гэдгээ ч анзаардаггүй.

Та хэрэглэгч үйлчлүүлэгчтэйгээ хэрхэн харилцаж ойлголцож чадаж байна, тэр бол танай брэндийн дуу хоолой, түүгээр дамжуулж таны үйлчлүүлэгч хэрэглэгчид танай бизнес рүү ойртон ирэх эсвэл холдон зугтах сонголтоо хийдэг. Тэгвэл ийм хүчтэй бизнесийн үйлчлүүлэгчтэйгээ харилцах харилцааны аргачлалтыг бид энэ модуль дээр суралцах болно.

//

ТАНЫ БУСАДТАЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦААНЫ ЧАДВАР ХУВИЙН Ч, БИЗНЕСИЙН Ч АМЖИЛТЫН ТАНЬ 85%-ИЙГ ЭЗЭЛНЭ.

BRIAN TRACY

- МОДУЛЬ 6 -

МИНИЙ БИЗНЕСИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

МОДУЛЬ ЗУРГАА.

МИНИЙ БИЗНЕСИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

ОНЛАЙН УУЛЗАЛТЫН ӨДӨР:
10 САРЫН 18 НЯМ 18 ЦАГ
(УБ ЦАГААР)

Онлайн уулзалтанд оролцох
Zoom Application Meeting ID:
595-159-216

МОДУЛЬ ЗУРГАА.

МИНИЙ БИЗНЕСИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Энэ модуль Монголын өнөөгийн нийгэмд хамгийн их дутагдаж эрэлт хэрэгцээнд орж буй Зохион Бүтээх буюу Innovation хэмээх гайхалтай чухал сэдвийг хөндөж суралцана. Зохион бүтээх авъяасгүй гэж боддог хүн ч даруй ашиглаж болохуйц гайхалтай сонирхолтой аргуудыг ярилцана.

Энэ аргуудыг ашиглаад та зах зээлд эрэлт хэрэгцээтэй бүх төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний загварт тусгаж ашиглаж болно. Ганцхан долоо хоногийн дараа л та өөрийгөө ямар их бүтээлч сэтгэлгээтэй, үнэ цэнэтэй хүн болохоо таньж, эрч хүч мэдрэх болно.

Бизнесийн хамгийн үнэ цэнэтэй, өндөр орлого ашигтай, чанартай бүтээгдэхүүнийг хийж сурахад би таныг дасгалжуулах болно.

//

ИННОВАЦИ БОЛ УДИРДАГЧДЫГ ДАГАЛДАГЧААС ТУСГААРЛАЖ, ЯЛГАРУУЛЖ ТОДРУУЛДАГ.

STEVE JOBS

- МОДУЛЬ 7 -

МИНИЙ БИЗНЕСИЙН МАРКЕТИНГ

МОДУЛЬ ДОЛОО.

МИНИЙ БИЗНЕСИЙН МАРКЕТИНГ

ОНЛАЙН УУЛЗАЛТЫН ӨДӨР:
10 САРЫН 25 ӉЯМ 18 ЦАГ
(УБ ЦАГААР)

Онлайн уулзалтанд оролцох
Zoom Application Meeting ID:
595-159-216

МОДУЛЬ ДОЛОО.

МИНИЙ БИЗНЕСИЙН МАРКЕТИНГ

Бизнесийн хамгийн чухал элемент Маркетинг, Маркетинг, Маркетинг. Сэтгэлд хоногших гайхалтай зохиомжоор хийсэн маркетинг хэний ч сэтгэлийг гижигдэж өөрийн эрхгүй гэгэлзүүлж догдлуулдаг. Тэгвэл би таныг үйлчлүүлэгчийнхээ сэтгэлд хоногших зохиомж, найруулга бичих нууцыг энэ модуль дээрээ хуваалцана.

Хэзээ ч хуучрахгүй нөлөөтэй маркетинг хийх сэтгэлгээний нууцыг хэрхэн зангидаж буулгах талаар харамгүй хуваалцаж таныг бизнестээ тохирох арга барилаа олоход шаардлагатай аргуудыг зааж өгөх болно. Та нэг л удаа эдгээр аргуудыг эзэмшчихэд бизнесийн 10 жилийн туршид ч таны маркетинг хийх чадварууд улам хөгжсөөр байх болно.

Маркетингийн чадвар өсөх тусал, халаасанд тань мөнгө урсан орж ирэхийг мэдрэх юутай гайхалтай гээч!

//

АГУУ БИЗНЕС ЭРХЛЭГЧИД ДЭЛХИЙГ ӨӨРЧЛӨХ ГЭЖ БИЗНЕСЭЭ ЭХЭЛДЭГ БОЛОХООС ХУРДХАН МӨНГӨ ХИЙХ ГЭЖ ЗОРЬДОГГҮЙ.

GUY KAWASAKI

- МОДУЛЬ 8 -

МИНИЙ БИЗНЕСИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

МОДУЛЬ НАЙМ.

МИНИЙ БИЗНЕСИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ОНЛАЙН УУЛЗАЛТЫН ӨДӨР:
11 САРЫН 01 НЯМ 18 ЦАГ
(УБ ЦАГААР)

Онлайн уулзалтанд оролцох
Zoom Application Meeting ID:
595-159-216

МОДУЛЬ НАЙМ.

МИНИЙ БИЗНЕСИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Та ямар ч бизнес эрхэлсэн хамаагүй, бид бүгд өдөр тутмын бүх мэдээллээ онлайнаар авч байна. Таны вэбсайт бол онлайн бизнес машин л гэсэн үг. Онлайнаар хамгийн хүчтэй нөлөө бүхий бизнес машин бүтээхэд чухал элементүүд, гайхалтай аргуудыг энэ модуль танд заана.

Энэ модульд таныг вэбсайт яаж хийх талаар анхан шатны мэдлэггүй хүн ч ойлгохоор амархан хурдан аргуудыг бие дааж хийж сурахад үе шаттайгаар зааж өгнө. Вэбсайтаа сайн мэдэж ойлгодог байх нь танд хянах эрх мэдэл, мөнгө, цаг, хөлс хүч хэмнэх болно. Вэб хөгжүүлэгч, бизнес эрхлэгчдийн хооронд гардаг олон бэрхшээлийг та шийдэх чадвартай алсын хараатай удирдагч болох гарааг эндээс эхлэх болно. Глобал зах зээлд outsourcing хийх гайхалтай нөөц боломжуудыг олж нээж ашиглаж сурна.

Энэ модуль таныг компьютер техникийн ажлаас айхгүй бүтээж сургах болно

//

МЭДСЭНИЙГЭЭ ХЭР ХЭРЭГЖҮҮЛЖ ЧАДАЖ БАЙГАА ДЭЭРЭЭ АЖИГЛАЛТ ХИЙЖ, МЭДЛЭГЭЭ БҮРЭН АШИГЛАЖ ТОГЛО

MARK ZUCKERBERG

ENTREPRENEUR CLUB - БАЯЛГИЙН СҮЛЖЭЭГЭЭ ХЭРХЭН ӨРГӨЖҮҮЛЖ ДЭМЖЛЭГТЭЙ САЙХАН ХАМТ ОЛНЫГ БИЙ БОЛГОХ ВЭ?

ӨӨРИЙН БИЗНЕСТЭЭ ЭХЛЭЭД ТӨВЛӨР

Та бизнесээ мэдэхгүй, таны бизнесийн үйл ажиллагаа муу, алсын хараагаа бүрэн боловсруулж амжаагүй бол та хэнтэй ч хамтран ажиллахад бусдын амыг дагах, буруу зөрүү ойлголцох гэх мэт олон янзын харилцааны эрсдэлд өртөх магадлал их бий. Та эхлээд өөрийн бизнестээ л анхаарлаа төвлөрүүл.

ӨӨРИЙГӨӨ БУСАДТАЙ БҮҮ ХАРЬЦУУЛ

Хүн болгон өөр. Энэ хөтөлбөрт хүн болгон өөр өөр мэдлэг, туршлагатай. Тантай адилхан хүн хаана ч байхгүй. Өөрийгөө бусадтай харьцуулах нь таны хувийн чадвар бүтээмжийг сулруулах аюултай.

БУСДЫН ХОВ ЖИВД БҮҮ ОРОЛЦ

Энэ бол таны бизнесийн амжилтанд асар хортой, элбэг тохиолддог муу зуршил. Гэмгүй энгийн яриан дундаас л хов жив өрнөдөг. Оюун ухаанаа ийм хорноос хамгаалж эерэг бодол, бусдын талаар эерэг бодлоор төлөвшөөрэй.

ТАТГАЛЗАХ ЭРХ ТАНД БИЙ

Хэрэв танд ашиггүй, таны сэтгэлгээ бизнесийн зорилгод авцалдахааргүй, хүссэн үр дүнгээ бүтээхэд тань онцын хувь нэмэр байхгүй ажил санал болгосон хэнтэй ч хамтран ажиллах алба танд байхгүй.

ЗОРИЛГОТОЙ ТОДОРХОЙ ХАРИЛЦАА ӨРНҮҮЛ

Тодорхой бус байснаас бусадтай үл ойлголцох,буруу зөрүү зөрчилдөөнд өртөх нь их. Хэнтэй ч харилцсан өөрийн зорилгодоо ч, үйлдэлдээ ч, харилцаандаа ч маш тодорхой байж хариуцлагатай хандаарай.

БУСДЫН ЯРИАГ ТЭВЧЭЭРТЭЙ САЙН СОНС

Бизнесийн ч бай, хувийн ч бай харилцаанд бусдыг тэвчээртэй сонсож сурах нь таны амжилтанд асар өндөр үр өгөөж өгдөг. Яаралгүйгээр тайван хандаж, сайн ойлгосны дараа шийдэл гаргаж үйлдэл хийх нь таныг өөртөө итгэлтэй олондоо нэр хүндтэй болгоно.

“МИНИЙ БИЗНЕС” ХӨТӨЛБӨРИЙН ТӨГСӨЛТИЙН СЮРПРИЗ УУЛЗАЛТАНД ТАНЫГ УРЬЖ БАЙНА

Бид жил болгоны эрчимтэй 2 сарын хөтөлбөрөө заасны дараа бүх оролцогчдоо сурсан мэдсэнээ ярих онцгой цагийг бие биентэйгээ хуваалцдаг.

ХЭЗЭЭ:
2020 ОНЫ
09 сарын 06-ны
ӨДӨР 18 ЦАГТ (УБ ЦАГААР)

ХААНА:
ZOOM APPLICATION
MEETING ID
595-159-216

Та бид модулийн хичээлийнхээ онлайн уулзалтанд оролцдог шигээ л Баасан гаригтаа онлайнаар уулзалдах болно.

Бүх оролцогчид хөтөлбөрийн хичээлүүдийнхээ явцад юу суралцсанаа, яаж бизнестээ хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байгаа тухайгаа ярилцах

ЯРИХ СЭДЭВ:
ТАНЫ АМЖИЛТ, БИЗНЕСИЙН ТУХАЙ

БЭЛТГЭЛ:
ГОЁЛЫН ХУВЦАСАА ӨМСЖ, ДУРТАЙ ДАРСАА БЭЛТГЭЭРЭЙ

Энэ бол та бидний цоо шинэ бизнесийн сэтгэлгээг тэлж эхэлсэний эхний жилийн төгсөлтийн баяр шүү дээ.



ХӨТӨЛБӨРИЙН САЙТ ТҮР ХААГДАХ ӨДӨР:
06 САРЫН 01

СЭТГЭЛ ДОГДЛОМ СТУДИ ЯРИЛЦЛАГА ХИЙХ ӨДӨР, УУЛЗАХ ГАЗАР:

ХӨТӨЛБӨРИЙНХӨӨ ВЭБСАЙТНААС ХАРНА УУ.

ХӨТӨЛБӨРИЙН ХААЛТ

СЭТГЭЛ ДОГДЛОМ ЯРИЛЦЛАГА СТУДИ УУЛЗАЛТ

Бид жил бүр оролцогчдоо сэтгэл догдлом энэ гайхалтай мөчөөр дамжуулан уулзалдаж ид шидийн ертөнцөд аялсан туршлагийнхаа дараа сюрприз уулзалтыг хийдэг. Энэ уулзалт бол таныг өөрөө өөртөө зориулж хөрөнгө оруулалт хийсэн амжилтаа бусадтай хуваалцах боломж өгөх зорилгоор бэлтгэгддэг.

Энэ өдөр та манай багийн залуусын зохион байгуулсан бичлэгийн студид хүрэлцэн ирэх бөгөөд чин сэтгэлээсээ ярилцлага өгөх юм. Энэ яриа таны өөрчлөлтөөсөө ундран гарсан сэтгэгдэлээ хуваалцахад зориулж бөгөөд бид хөтөлбөрийн өмнөх үеийн нөхцөл байдлаа ярьж байсан үеэсээ хэр зэрэг өөрчлөгдсөнөө өөртөө зориулж харьцуулан харах зориулалттай.

ТАНЫ ТӨГСӨЛТИЙН СЕРТИФИКАТ ГАРДУУЛАХ ЁСЛОЛ
Энэ өдөр төгсөлтийн баяраа бүх оролцогчидтойгоо хамтран тэмдэглэхийн ялдамд амжилттай төгссөн сертификатаа хүлээн авах болно. Таалагддаг хувцсаа өмс, өөрөөрөө байгаарай. Энэ бол таны амжилт!

ӨНӨӨДӨР МИНИЙ АЛСЫГ ХАРЖ ЧАДАЖ БАЙГАА ЧАДАЛ БОЛ МИНИЙ ӨМНӨ АМЖИЛТАНД ХҮРСЭН ХҮМҮҮСИЙН МӨРӨН ДЭЭР ЗОГСОЖ БАЙГААД Л УЧИР НЬ БАЙГАА ЮМ.

МИНИЙ БИЗНЕС

ОНЛАЙН ДАСГАЛЖУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР

COPYRIGHT © 2009-2020 WWW.MONICABATSUKH.COM
ОЮУНЫ БҮТЭЭЛИЙГ ХУУЛБАРЛАХЫГ ХОРИГЛОНО.

“МИНИЙ БИЗНЕС”
ОНЛАЙН ДАСГАЛЖУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР

COPYRIGHT © 2009-2020
WWW.MONICABATSUKH.COM
ОЮУНЫ БҮТЭЭЛИЙГ ХУУЛБАРЛАХЫГ ХОРИГЛОНО.